



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/431

Зуунмод

“Бизнес уулзалт” зохион байгуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчдийг дэмжих” урианы жил, Зуунмод хотын 80 жилийн ойн хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч болон хувийн хэвшлийн төлөөлөл, хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгч нартай уулзах уулзалтыг сумын ИТХ-ын Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан хороотой хамтран зохион байгуулсугай.

2. Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Энхсайхан	-Засаг даргын орлогч
Гишүүдэд: Ц.Ууганбаатар	- Сумын ИТХ-ын төлөөлөгч
Т.Гэрэлмаа	- Сумын ИТХ-ын төлөөлөгч
Р.Энхбаяр	- Сумын ИТХ-ын төлөөлөгч
О.Ганболд	- Сумын ИТХ-ын төлөөлөгч
Ш.Цэндсүрэн	- Сумын ИТХ-ын төлөөлөгч
Д.Өнөрбаяр	-ХАА-н тасгийн мэргэжилтэн
Г.Уянга	-ХАА-н тасгийн мэргэжилтэн
	-Багийн Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар

Нарийн бичгийн дарга: Б.Батжаргал -ХАА-н тасгийн дарга

3. “Бизнес уулзалт” зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Энхсайхан)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Батжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ

